


ЭЛЧИН САЙД ЯРЬЖ БАЙНА

Австрали улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Жон Лангтри: Манай оронд төрийн оролцоотой компани байхгүй.



Австрали улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Жон Лангритай ярилцлаа.

-Та Австралиас Монголд сууж байгаа анхны Элчин сайд. Австрали улс Монголд Элчин сайдын яамаа нээх болсон шалтгаанаас яриагаа эхэлье?

-Би Канберрад ажиллаж байхдаа Монголын асуудлыг давхар хариуцдаг байсан юм. Монголын талаас ЭСЯ-аа Улаанбаатарт нээгээч гэсэн хүсэлтийг манай улсад хэд хэдэн удаа тавьсан л даа. Австралид суугаа Монголын элчин байсхийгээд л ингэж асуудаг байсан шүү. Хоёр улс дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой ирэх баяртай юм.

ил тод байх хэрэгтэй. Хоёр дахь зарчим нь тогтвортой байх. Харин гурав дахь нь өөр хоорондоо уялдаатай байх. Энэ зарчмыг барьж ажиллах хэрэгтэй. МАН-ын тэргүүлж байгаа засаг энэ талаар ярьж эхэлсэн нь сайн хэрэг.

Монголд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжиж байгаа. Уул уурхайн салбарын сайн засаглалыг хөгжүүлэх, чадавхийг сайжруулахад төвлөрсөн хөтөлбөр л дөө. Манай улс эдийн засгаа хөгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтад ач холбогдол өгдөг. Гадаадын хөрөнгө оруулалт хүмүүст ашиг тус өгч байгаа төлөхийг

Энэ бодлого компаниудын орон нутаг хандив өгөх урмыг сэргээж өгдөг. Мэдээж би бүгдийг ойлгосон гэж хэлэхгүй, гэхдээ Монголын хувьд өөр бодлого барьдаг гэж ойлгосон. Донрын янз бүрийн тусламж үзүүлдэг байгууллагуудын дагаж мөрдөх ёстой татварын хууль нэлээд чанга талдаа гэж анзаарагдсан. Тухайлбал, танай улсад компаниудын орон нутгийн хөгжилд зориулан өгч байгаа хандив тусламж татвараас чөлөөлөгддөггүй хуулийн зохицуулалт үйлчилдэг.

-Манай улсын нөөц ихтэй ордууд стратегийн гэсэн ангилалд багтдаг. Тэр ордуудад төрийн оролцоо өндөр байдаг. Ер нь уул уурхайн бизнест төр оролцох нь хэр зөв хандлага вэ. Австралид төр нь уул уурхайн бизнестээ оролцдог жишээ байна уу?

-Австралийн хувьд эдийн засгийг хөгжүүлэх хамгийн шилдэг арга бол эдийн засгаа нээлттэй байлгах гэдгийг ухаарсан. Тийм учраас манай улсад төрийн оролцоотой компани байхгүй. Төр нь тодорхой хэмжээний хувь эзэмшдэг уул уурхайн компани байхгүй. Төрийн нислэгийн компанитай байснаа хувьчилсан. Төмөр зам, далайн тээвэр, арилжааны банк ч ялгаагүй, бүгд хувийнх. Австралид гадаад, дотоодын компани гэж ялгагдаггүй. Бүгдэд адил дүрэм журам үйлчилдэг. Цаашид ямар бодлого хэрэглэх нь боддог

үед ардчилал, чөлөөт зах зээлийг сонгосон Монголыг яаж дэмжих вэ гэдэг хэлэлцүүлэг Австралид өрнөсөн. Эцэст нь Монгол гэдэг улсыг цааш нь удирдаж авч явах хүмүүсийг нь боловсролоор дэмжжэ гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр магистр, докторын түвшний сургалтад төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийг хамруулах хэлбэрээр эхэлсэн. Эхэндээ төрийн албаныхныг түлхүү хамруулсан ч яваандаа хувийн салбарынхныг ч шалгаруулах болсон. Одоогоор Австралийн Засгийн газрын тэтгэлгээр хувийн болон төрийн албанд ажиллаж байгаа 400 гаруй хүн суралцаад байна. Хувийн зардлаараа суралцсан хүмүүсийг нэмбэл 6000 гаруй монгол хүн манай улсад суралцсан байдаг юм. Австралид сураад ирсэн залуус Монголын хөгжилд том хувь нэмэр оруулж байгаад баяртай явдаг. Австралид төгссөн монголчууд Mozzies нийгэмлэг гэж байгуулсан байгаа. Ийм том нийгэмлэг Монголд байгуулагдчихсан үед сайдаар ирсэн нь миний хувьд аз завшаантай хэрэг. Дашрамд хэлэхэд, хоёр дахь үеийн Mozzies-ууд гараад ирчихсэн. Австралид боловсрол эзэмшсэн, Австралид амьдарч байгаа хүмүүсийн хүүхдүүд манай улсад боловсрол эзэмшиж байна. Үнэхээр талархуштай хэрэг шүү. Австралид суралцсан монголчууд биеийн

гарагт гэхэд л "Хил хязгааргүй Австрали" гэдэг боловсролын үзэсгэлэн болох гэж байна. Австрали болон дэлхийд нэлээд дээгүүрт ордог 15 их сургуулийн төлөөлөгч ирнэ. Австралид сурах сонирхолтой хүмүүс сургуулиудаас нь шууд мэдээлэл авах боломж нээгдэж байгаа гэсэн үг.

-Австралид ажиллах сонирхолтой монголчууд олон бий. Ийм хүсэлтэй хүмүүст визний хувьд хөнгөлөлт ч юм уу, тодорхой дэмжлэг үзүүлэх боломж хэр байгаа вэ?

-Оюутнуудын хувьд санхүүгийн чадвараа баталбал гэр бүлээ аваад явж болдог. Австралигадаа оюутнуудад долоо хоногт тодорхой цагаар ажиллах зөвшөөрөл өгдөг. Хичээлээ гүйцээд шалгалтуудаа сайн өгөөд байвал сурахынхаа хажуугаар ажиллаж болно гэж Австралийн Засгийн газар үздэг. Манай тогтолцооны хүмүүсийг илүү ихээр татдаг элемент нь энэ болов уу. Австралийн хувьд ажиллах болон амрах гэсэн визний төрөл бий. Жуулчны визтэй төстэй ч жуулчлангаа ажил эрхлэх боломжоор хангадаг юм. Австрали улс энэ визийг нэлээд олон оронд хэрэгжүүлдэг. Монголын хувьд хамрагдах боломжтой. Засгийн газрын хэмжээнд ярьж байна. Мэдээж хоёр талд ижилхэн боломж үйлчлэх хэрэгтэй. Австраличуудад ч ийм боломжийг өгөх учиртай гэж бодож байна. Гадаад харилцааны сайр У.Мун

хуваалцаач?

-Монголд ирсэн хүн бүрд хүчтэй сэтгэгдэл төрдөг байх шүү. Би өмнө нь Монголоос гадна Япон, Солонгосын хойгийг хариуцаж ажилладаг байсан юм. Хариуцдаг улсын хувьд танай оронд өмнө нь дүн өвлөөр ирж байсан. Монголын өвөл ямар хүйтнийг ярих юм биш. Би Монголд ирэхээс өмнө энэ ертөнцийн хамгийн хүйтэн газрыг Берлин гэж боддог байсан шүү (инээв).

-Таныг монгол хэл сурч байгаа гэж сонслоо. Хэр хэцүү санагдаж байна?

-Бихоёр мэргэжилтэй. Эхний мэргэжил маань инженер. Дараа нь хэл шинжээчийн мэргэжил эзэмшсэн. Монгол хэл сурахад хэцүү байна. Гэхдээ мэргэжил маань хэл шинжээч учраас их сонирхон сурч байгаа. Би японоор ярьдаг. Япон хэлтэй хэлнийх нь үндэс нэг учраас сурахад харьцангуй амар юм. Япон хэлний авиа зүй хялбархан байдаг. Англи хэлийг японтой харьцуулбал бага зэрэг хүндрэлтэй. Гэтэл монгол хэл их өөр. Англи хэлэнд ч байдаггүй маш олон авиа, дуудлага байна. Үг бүр нь хэцүү санагдаж байгаа шүү (инээв). Монгол хэлийг өгөөрмөц, сонирхолтой сонсогдуулдаг нэг зүйл байна. Хоолойн лх гэх мэт хоёр гийгүүлэгчийг нийлүүлж хэлэхээр гардаг авиа. Монгол хэлний характерыг ямар нэг зүйлтэй зүйрлээч гэвэл би уурын зүтгүүр шиг гэнэ. Яруу найраг сонсохор ямар мэдрэмж төрдөг билээ, яг тэгж

адаад хэргийн сайд Элчин сайдын яамаа нээх цаг болсон гэж үзсэн. Австралийн хувьд улс орнуудад ЭСЯ-аанэг их нээгээд байдаггүй. Ялангуяа өнөө цагт. Өнгөрсөн арванхоёрдугаар сард Монгол Улсад Элчин сайдын яамаа нээсэн нь танай орныг стратеги, эдийн засаг, нийгмийн түншийн хувьд хүлээн зөвшөөрч байгаа хэрэг. Стратегийн хувьд гэж яривал ардчилал, зах зээлийн эдийн засгийг зориглон сонгож, тогтвортойгоор хөгжүүлж байгаад нь Монгол Улсаар бахархдаг. Австрали улс Монголын хувьд сайн гуравдагч хөрш байхыг хүсдэг. Эдийн засгийн хувьд ч манай хоёр улсад ижил тал бий. Аль аль нь өндөр чанартай гадаадын хөрөнгө оруулалтыг экспортын баримжаатайгаар уул уурхайн салбарт татаж эдийн засгаа хөгжүүлж байгаа. Нийгэм, хүмүүсийн хувьд ч монгол, австраличуудад төстэй тал их бий. Гэр бүлийг дээдэлдэг, боловсролыг өндөр хэмжээнд чухалчлан үздэг, гадаадын ямар нэг соёлыг маш хурдан хүлээн зөвшөөрч чаддаг, нүүдлийн уламжлалаас улбаатай байгалийг хайрлах үзэл гэж ирээд яривал хоёр улсын иргэдэд адил зүйл олон байдаг. Сая дурдсан эдгээр нь Элчин сайдын яамаа нээх шалтгаан болсон.

-Уул уурхайгаасаа олсон мөнгөөр бусад салбараа тэтгэж хөгжихөөс өөр бодитой гарц бидэнд байхгүй. Австрали уул уурхайн хөгжлөөрөө дэлхийд жишиг болсон орон. Уул уурхайгаа зөв замаар хүчтэй хөгжүүлэхийн тулд юун дээр анхаарах ёстой гэж та бодож байна?

-Австралийн тухайд том төслүүдэд гадны хөрөнгө оруулалтыг татаж амжилттай хэрэгжүүлэх тал дээр арвин туршлагатай. Уул уурхайн салбартаа түшиглэн эдийн засгаа босгох гэж байгаа танай орны хувьд манайх шиг улсын алдаа, онооноос сурах зүйл өчнөөн бий. Австрали уул уурхайн хайгуул, олборлолтын шатанд хэрэгжиж байгаа хууль эрх зүйн орчин, бодлого, журам зохицуулалт дээр гурван зарчмыг маш хатуу барьдаг. Юуны түрүүнд тодорхой,

мэднэ. Адаадын хөрөнгө оруулалтын үр ашиг олон түмэнд ил тодорхой байна гэдгийг төсөв томорсноор хэмжих нь учир дутагдалтай. Үр ашиг нь орон нутгийн түвшинд харагдаж байх учиртай. Өндөр чанартай гадны хөрөнгө оруулалтыг татах хэрэгтэй гээд байгаа нь цаанаа ийм утгатай. Базаад хэлбэл, хөрөнгө оруулалтын ашиг тус нь үндэсний болон орон нутгийн түвшинд ижилхэн мэдрэгдэх ёстой.

-Уул уурхайдаа түшиглээд бусад салбараа хөгжүүлсэн жишээ өчнөөн байх...?

-Байлгүй яахав, жишээ нь тогтвортой хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх боломж бий. Орон нутагт уул уурхайгаас хамааралгүй хөдөө аж ахуйг хөгжүүлчихвэл уул уурхайн компаниуддаа бүтээгдэхүүнээ нийлүүлээд зогсохгүй. Уул уурхайн компани ажиллахаа больсон ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд нийлүүлж, илүү гарсныг нь экспортлох чадвартай хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. "Рио Тинто" гэхэд л Австралид төмрийн хүдрийн уурхайгаа түшиглэж хөдөө аж ахуйн төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Уурхайд хэрэглэсэн усаа цэвэршүүлээд малын тэжээл ургуулах бизнесийг дэмжсэн амжилттай жишээ бий. Иймэрхүү ижил төстэй төсөл хөтөлбөрийг Монголд хэрэгжүүлэх сонирхол "Рио"-д байгаа байх.

-Гадаадын хөрөнгө оруулалт орон нутагт ч үр ашгаа өгөх ёстой гэж та түрүүн ярилаа. Манай улсын хувьд энэ тал дээр дутмаг тал анзаарагддаг. Бодлогын хэмжээнд анхаарах зүйл байна уу?

-Австрали холбооны Засгийн газартай. Уул уурхайн чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, хууль нь муж, мужаараа ялгаатай. Гэхдээ байгаль орчны чигийн хуулиудын тухайд улс даяар ижил байх бодлого барьдаг. Уул уурхайн чиглэлийн компаниуд орон нутагт хандив тусламж өглөө гэхэд холбооны улсын татварын хуулиар зохицуулах жишээний. Австрали улс орон нутагт тусламж дэмжлэг үзүүлсэн компаниудад эргээд татварын хөнгөлөлт үзүүлдэг.

сайн шүүгч нь мөнгөл мөнгөлүүд өөрсдөө. Монголын нэг олзуурхам зүйл нь ардчилал маш сайн бэхэжсэн. Хүмүүс нь үзэл бодлоо нээлттэйгээр солилцож, маргаан мэтгэлцээн өрнүүлж чаддаг. Зөв шийдвэрт хүрэх механизм нь байгаа гэсэн үг.

-Монголд хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр хийх зүйл их байна гэж та ярьсан байсан. Энэ салбаруудад яг ямар боломжууд харагдаж байна вэ. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бий гэж ойлгож болох уу?

-Олон улсын байгууллага, Монголын Засгийн газар, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд, Монголын бизнесмэнүүдийг нэгтгэж хөдөө аж ахуйн салбарт томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхол бий. Гэхдээ төр, хувийн хэвшлийг хамтын оролцоог бий болгоход хугацаа шаардагддаг. Одоогоор Австралийн Засгийн газраас Монголд орж ирж байгаа хөгжлийн тусламжид хөдөө аж ахуйн салбарт зориулсан мөнгө төсөвлөгдөөгүй. Австралийн хувьд төсвийн алдагдлаа бууруулах чиглэлээр нэлээд чармайж ажилласан. Гадны улсад үзүүлдэг хөгжлийн тусламжийн мөнгөнөөсөө нэлээд танаад байгаа. Монголын хувьд гол гэж үзсэн хоёр салбарт тусламж үзүүлж байна. Нэг нь Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр. Нөгөө нь боловсролын салбарт хэрэгжиж байгаа Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр.

-Австралийн Засгийн газрын тэтгэлэгт ихэвчлэн төрийн албан хаагчид хамрагдаад байх шиг анзаарагддаг. Австралид сурах сонирхолтой хувийн хэвшлийн залууст боломж хэр байдаг вэ?

-Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хувьд зөвхөн төрийн албанд ажилладаг хүмүүст зориулсан тэтгэлэг биш. Энэ тэтгэлэг Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1992 оноос эхлэлтэй. Монголд өрнөсөн ардчилал дэлхий дахинд сюрприз болсон. Тухайн

хэлний чанартай боловсрол авахаар сонгодог улсын дотор Австрали АНУ-ын дараа хоёрт жагсдаг. Энэ бямба (маргааш)

орчин бүрдүүлж болно гэсэн хариу хэлсэн.

-Монголд ирээд төрсөн хүчтэй сэтгэгдлээ

үүсэл хөгжлийн баялаг түүхтэй байдаг.

Ц.БААСАНСҮРЭН

ШАРАВЫН ШАГДАР (1933-2016)



Монгол Улсын боловсрол, шинжлэх ухааны зүтгэлтэн, Ардын багш, Боловсрол судлалын шинжлэх ухааны доктор, профессор Ш.Шагдар 2016 оны есдүгээр сарын 14-нд өвчний улмаас таалал төгсөж, бидэнд хүнд гарз тохиолдлоо.

Ш.Шагдар нь 1933 онд Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт Бор толгой гэдэг газар төрсөн. Тэрбээр 1942-1949 онд Халзан сумын 7 жилийн дунд сургууль, 1949-1951 онд Улаанбаатар хотын Багшийн сургууль, 1954-1957 онд Улсын Багшийн институтэд суралцан газар зүйн багшийн мэргэжил эзэмшжээ.

Ш.Шагдар нь 1951 онд Улаанбаатар хотын 3 дугаар дунд сургууль, 1952-1954 онд Сүхбаатар аймгийн төвийн дунд сургууль, 1957-1961 онд Улаанбаатар хотын Багшийн сургуульд багш, 1961-1972 онд Гэгээрлийн яам, Ардын боловсролын яаманд байцаагч, хэлтсийн дарга, 1972-1983 онд Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, заах арга зүйч, салбарын эрхлэгч, 1983-1991 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтын захирал, 1991-1997 онд УБИС-д багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаад өндөр насныхаа тэтгэвэрт гарсан ба 1997 оноос "Газарчин" дээд сургуульд дэд захирал, зөвлөх багшаар, нийтдээ Монгол Улсын боловсролын салбарт 61 жил өөрийн хүч хөдөлмөрөө зориулсан авьяаслаг сурган хүмүүжүүлэгч байсан юм.

Тэрбээр 1979 онд "Монголын газар зүйн хичээлээр орон нутгаа судлах нь" сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны дэд эрдэмтний, 2002 онд "Монголын боловсролын түүхийн зарим асуудал" сэдвээр Боловсрол судлалын шинжлэх ухааны доктор(Sc.D)-ын зэргийг тус тус хамгаалж, профессор цол хүртжээ.

Ш.Шагдар ЕБС-ийн багш нарын тэргүүн туршлага, ажлын арга технологийг илрүүлэн судлах, нийтийн хүртээл болгож түгээн дэлгэрүүлэх, тэдний мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулж болгох, материаллаг баазыг бэхжүүлэх талаар ихээхэн анхаарч ажиллан, өнөөгийн Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтын үндэс суурийг тавилцсан гавьяатнуудын нэг байлаа.

Профессор Ш.Шагдар нь Монгол Улсын боловсролын салбар, тэр дундаа газарзүйн боловсролын салбарт ухамсарт амьдралаа зориулсан бөгөөд газарзүйн багш, мэргэжилтэн бэлтгэх, Монгол орны атлас, газарзүйн зураг, сурах бичиг зохиох ажилд ихээхэн хувь нэмэр оруулж, ялангуяа газарзүй заах аргын салбарт өөрийн гэсэн "сургууль"-ийг бий болгожээ.

Тэрбээр их, дээд сургуульд багшлах хугацаандаа "Боловсролын түүх", "Монголын аялал жуулчлалын түүх газар зүй", "Монголын орон нутаг судлал" хичээлүүдийн хөтөлбөрүүдийг анх санаачлан боловсруулсан нь МУБИС, МУИС, "Газарчин", "Цог" болон "Дорно дахины дээд сургууль"-ийн сургалтанд ашиглагдсаар байна.

Ш.Шагдар нь боловсрол судлал, газар зүйн ухаанаар дэд доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлүүдийн гишүүн, газарзүйн олимпиадын хорооны дэд тэргүүн, газар зүйн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байснаас гадна Боловсролын шинжлэх ухааны академийг үүсгэн байгуулалцсан бөгөөд энэ академийн жинхэнэ гишүүн, дэд ерөнхийлөгч, Монголын багш нарын холбооны анхны даргын сонгуульд ажлыг гүйцэтгэж байлаа.

Түүний бие даасан болоод бусадтай хамтран туурвисан 100 шахам ном бүтээлийн дотор манай орны аялал жуулчлалын ажил болон сургалт эрхлэгчдийн үндсэн гарын авлага болсон "Монгол орноор жуулчлах 100 зам", "Монгол орны газарзүйн нэрийн товч толь бичиг", манай улсын боловсролын түүхийн үндсэн тулгуур бүтээл болох "Монголын боловсролын түүх" (3 боть) зэрэг бүтээлүүд байгаа бөгөөд эдгээр нь англи хэл болон хуучин монгол бичгээр хэвлэгдэж гарсан байдаг. Түүнчлэн "Эх газрын газарзүй", "Монголын физик газарзүй", "ЕБС-д газарзүй заах арга" зэрэг сурах бичгүүдийг зохиож редакторласны дотроос "Монголын физик газарзүй" (зохиогч Ш.Цэгмид) сурах бичиг нь 1984 онд төрийн шагнал авсан юм.

Тэрбээр 1978 онд "Монголын нутгийн газар зүйн төв (хүйс) цэг Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Өвөр хөшөөтөд оршдог гэдгийг солбилцлын аргаар бодож тогтоосон нь онцгой ач холбогдолтой ажил болсон.

Талийгаачийн хөдөлмөр бүтээлийг төр, засгаас үнэлж "Ардын гэгээрлийн тэргүүний ажилтан", "Байгаль орчны тэргүүний ажилтан", "Аялал жуулчлалын тэргүүний ажилтан", "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч" цол тэмдэг, "Засгийн газрын хүндэт жууц", "Алтан гадас" одон, "Монгол Улсын гавьяат багш", "Монгол Улсын Ардын багш" цолоор тус тус шагнажээ.

Түүний хүнлэг, эх оронч, хөдөлмөрч, элэгсэг дотно харьцаа гэгээн дүр нь бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн дурсагдах болно.

**Ц.ЭЛБЭГДОРЖ, М.ЭНХБОЛД, Ж.ЭРДЭНЭБАТ,
Л.ЭНХ-АМГАЛАН, Ж.БАТСУУРЬ, Ч.УЛААН, Ж.БАТЗАНДАН,
Б.ГАНСҮХ, З.ЭНХТӨР**

Гадаад хэргийн сайд Элчин сайдын яамаа нээх цаг болсон гэж үзсэн. Австралийн хувьд улс орнуудад ЭСЯ-аа нэг их нээгээд байдаггүй. Ялангуяа өнөө цагт. Өнгөрсөн арванхоёрдугаар сард Монгол Улсад Элчин сайдын яамаа нээсэн нь танай орныг стратеги, эдийн засаг, нийгмийн түншийн хувьд ямар чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг. Стратегийн хувьд гэж яривал ардчилал, зах зээлийн эдийн засгийг зориглон сонгож, тогтвортойгоор хөгжүүлж байгаад нь Монгол Улсаар бахархдаг. Австрали улс Монголын хувьд сайн гуравдагч хөрш байхыг хүсдэг. Эдийн засгийн хувьд ч манай хоёр улсад ижил тал бий. Аль аль нь өндөр чанартай гадаадын хөрөнгө оруулалтыг экспортын баримжаатайгаар уул уурхайн салбарт татаж эдийн засгаа хөгжүүлж байгаа. Нийгэм, хүмүүсийн хувьд ч монгол, австраличуудад төстэй тал их бий. Гэр бүлийг дээдэлдэг, боловсролыг өндөр хэмжээнд чухалчлан үздэг, гадаадын ямар нэг соёлыг маш хурдан хүлээн зөвшөөрч чаддаг, нүүдлийн уламжлалаас улбаатай байгалийг хайрлах үзэл гэж ирээд яривал хоёр улсын иргэдэд адил зүйл олон байдаг. Сая дурдсан эдгээр нь Элчин сайдын яамаа нээх шалтгаан болсон.

-Уул уурхайгаасаа олсон мөнгөөр бусад салбараа тэтгэж хөгжихөөс өөр бодитой гарц бидэнд байхгүй. Австрали уул уурхайн хөгжлөөрөө дэлхийд жишиг болсон орон. Уул уурхайгаа зөв замаар хүчтэй хөгжүүлэхийн тулд юун дээр анхаарах ёстой гэж та бодож байна?

-Австралийн тухайд том төслүүдэд гадны хөрөнгө оруулалтыг татаж амжилттай хэрэгжүүлэх тал дээр арвин туршлагатай. Уул уурхайн салбартаа түшиглэн эдийн засгаа босгох гэж байгаа танай орны хувьд манайх шиг улсын алдаа, онооноос сурах зүйл өчнөөн бий. Австрали уул уурхайн хайгуул, олборлолтын шатанд хэрэгжиж байгаа хууль эрх зүйн орчин, бодлого, журам зохицуулалт дээр гурван зарчмыг маш хатуу барьдаг. Юуны түрүүнд тодорхой,

мэднэ. 1 адаадын хөрөнгө оруулалтын үр ашиг олон түмэнд ил тодорхой байна гэдгийг төсөв томорсноор хэмжих нь учир дутагдалтай. Үр ашиг нь орон нутгийн түвшинд харагдаж байх учиртай. Өндөр чанартай гадны хөрөнгө оруулалтыг татах хэрэгтэй гээд байгаа нь цаанаа ийм утгатай. Базаад хэлбэл, хөрөнгө оруулалтын ашиг тус нь үндэсний болон орон нутгийн түвшинд ижилхэн мэдрэгдэх ёстой.

-Уул уурхайдаа түшиглээд бусад салбараа хөгжүүлсэн жишээ өчнөөн байх...?

-Байлгүй яахав, жишээ нь тогтвортой хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх боломж бий. Орон нутагт уул уурхайгаас хамааралгүй хөдөө аж ахуйг хөгжүүлчихвэл уул уурхайн компаниуддаа бүтээгдэхүүнээ нийлүүлээд зогсохгүй. Уул уурхайн компани ажиллахаа больсон ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд нийлүүлж, илүү гарсныг нь экспортлох чадвартай хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. "Рио Тинто" гэхэд л Австралид төмрийн хүдрийн уурхайгаа түшиглэж хөдөө аж ахуйн төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Уурхайд хэрэглэсэн усаа цэвэршүүлээд малын тэжээл ургуулах бизнесийг дэмжсэн амжилттай жишээ бий. Иймэрхүү ижил төстэй төсөл хөтөлбөрийг Монголд хэрэгжүүлэх сонирхол "Рио"-д байгаа байх.

-Гадаадын хөрөнгө оруулалт орон нутаг ч үр ашгаа өгөх ёстой гэж та түрүүн ярилаа. Манай улсын хувьд энэ тал дээр дутмаг тал анзаарагддаг. Бодлогын хэмжээнд анхаарах зүйл байна уу?

-Австрали холбооны Засгийн газартай. Уул уурхайн чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, хууль нь муж, мужаараа ялгаатай. Гэхдээ байгаль орчны чигийн хуулиудын тухайд улс даяар ижил байх бодлого барьдаг. Уул уурхайн чиглэлийн компаниуд орон нутагт хандив тусламж өглөө гэхэд холбооны улсын татварын хуулиар зохицуулах жишээний. Австрали улс орон нутагт тусламж дэмжлэг үзүүлсэн компаниудад эргээд татварын хөнгөлөлт үзүүлдэг.

сайн шүүгч нь мөнгө мөнгөлөөдөө өөрсдөө. Монголын нэг олзуурхам зүйл нь ардчилал маш сайн бэхжсэн. Хүмүүс нь үзэл бодлоо нээлттэйгээр солилцож, маргаан мэтгэлцээн өрнүүлж чаддаг. Зөв шийдвэрт хүрэх механизм нь байгаа гэсэн үг.

-Монголд хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр хийх зүйл их байна гэж та ярьсан байсан. Энэ салбаруудад яг ямар боломжууд харагдаж байна вэ. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бий гэж ойлгож болох уу?

-Олон улсын байгууллага, Монголын Засгийн газар, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд, Монголын бизнесмэнүүдийг нэгтгэж хөдөө аж ахуйн салбарт томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхол бий. Гэхдээ төр, хувийн хэвшлийг хамтын оролцоог бий болгоход хугацаа шаардагддаг. Одоогоор Австралийн Засгийн газраас Монголд орж ирж байгаа хөгжлийн тусламжид хөдөө аж ахуйн салбарт зориулсан мөнгө төсөвлөгдөөгүй. Австралийн хувьд төсвийн алдагдлаа бууруулах чиглэлээр нэлээд чармайж ажилласан. Гадны улсад үзүүлдэг хөгжлийн тусламжийн мөнгөнөөсөө нэлээд танаад байгаа. Монголын хувьд гол гэж үзсэн хоёр салбарт тусламж үзүүлж байна. Нэг нь Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр. Нөгөө нь боловсролын салбарт хэрэгжиж байгаа Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр.

-Австралийн Засгийн газрын тэтгэлэгт ихэвчлэн төрийн албан хаагчид хамрагдаад байх шиг анзаарагддаг. Австралид сурах сонирхолтой хувийн хэвшлийн залууст боломж хэр байдаг вэ?

-Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хувьд зөвхөн төрийн албанд ажилладаг хүмүүст зориулсан тэтгэлэг биш. Энэ тэтгэлэг Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1992 оноос эхлэлтэй. Монголд өрнөсөн ардчилал дэлхий дахинд сюрприз болсон. Тухайн

хэлний чанартай боловсрол авахаар сонгодог улсын дотор Австрали АНУ-ын дараа хоёрт жагсдаг. Энэ бямба (маргааш)

орчинг бүрдүүлж болно гэсэн хариу хэлсэн.

-Монголд ирээд төрсөн хүчтэй сэтгэгдлээ

үүсэл хөгжлийн баялаг түүхтэй байдаг.

Ц.БААСАНСҮРЭН

ШАРАВЫН ШАГДАР (1933-2016)



Монгол Улсын боловсрол, шинжлэх ухааны зүтгэлтэн, Ардын багш, Боловсрол судлалын шинжлэх ухааны доктор, профессор Ш.Шагдар 2016 оны есдүгээр сарын 14-нд өвчний улмаас таалал төгсөж, бидэнд хүнд гэрз тохиолдлоо.

Ш.Шагдар нь 1933 онд Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт Бор толгой гэдэг газар төрсөн. Тэрбээр 1942-1949 онд Халзан сумын 7 жилийн дунд сургууль, 1949-1951 онд Улаанбаатар хотын Багшийн сургууль, 1954-1957 онд Улсын Багшийн институтэд суралцан газар зүйн багшийн мэргэжил эзэмшжээ.

Ш.Шагдар нь 1951 онд Улаанбаатар хотын 3 дугаар дунд сургууль, 1952-1954 онд Сүхбаатар аймгийн төвийн дунд сургууль, 1957-1961 онд Улаанбаатар хотын Багшийн сургуульд багш, 1961-1972 онд Гэгээрлийн яам, Ардын боловсролын яаманд байцаагч, хэлтсийн дарга, 1972-1983 онд Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, заах арга зүйч, салбарын эрхлэгч, 1983-1991 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтын захирал, 1991-1997 онд УБИС-д багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаад өндөр насныхаа тэтгэвэрт гарсан ба 1997 оноос "Газарчин" дээд сургуульд дэд захирал, зөвлөх багшаар, нийтдээ Монгол Улсын боловсролын салбарт 61 жил өөрийн хүч хөдөлмөрөө зориулсан авьяаслаг сурган хүмүүжүүлэгч байсан юм.

Тэрбээр 1979 онд "Монголын газар зүйн хичээлээр орон нутгаа судлах нь" сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны дэд эрдэмтний, 2002 онд "Монголын боловсролын түүхийн зарим асуудал" сэдвээр Боловсрол судлалын шинжлэх ухааны доктор(Sc.D)-ын зэргийг тус тус хамгаалж, профессор цол хүртжээ.

Ш.Шагдар ЕБС-ийн багш нарын тэргүүн туршлага, ажлын арга технологийг илрүүлэн судлах, нийтийн хүртээл болгож түгээн дэлгэрүүлэх, тэдний мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулж болгох, материаллаг баазыг бэхжүүлэх талаар ихээхэн анхаарч ажиллан, өнөөгийн Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтын үндэс суурийг тавилцсан гавьяатнуудын нэг байлаа.

Профессор Ш.Шагдар нь Монгол Улсын боловсролын салбар, тэр дундаа газарзүйн боловсролын салбарт ухамсарт амьдралаа зориулсан бөгөөд газарзүйн багш, мэргэжилтэн бэлтгэх, Монгол орны атлас, газарзүйн зураг, сурах бичиг зохиох ажилд ихээхэн хувь нэмэр оруулж, ялангуяа газарзүй заах аргын салбарт өөрийн гэсэн "сургууль"-ийг бий болгожээ.

Тэрбээр их, дээд сургуульд багшлах хугацаандаа "Боловсролын түүх", "Монголын аялал жуулчлалын түүх газар зүй", "Монголын орон нутаг судлал" хичээлүүдийн хөтөлбөрүүдийг анх санаачлан боловсруулсан нь МУБИС, МУИС, "Газарчин", "Цог" болон "Дорно дахины дээд сургууль"-ийн сургалтанд ашиглагдсаар байна.

Ш.Шагдар нь боловсрол судлал, газар зүйн ухаанаар дэд доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлүүдийн гишүүн, газарзүйн олимпиадын хорооны дэд тэргүүн, газар зүйн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байснаас гадна Боловсролын шинжлэх ухааны академийг үүсгэн байгуулалцсан бөгөөд энэ академийн жинхэнэ гишүүн, дэд ерөнхийлөгч, Монголын багш нарын холбооны анхны даргын сонгуульд ажлыг гүйцэтгэж байлаа.

Түүний бие даасан болоод бусадтай хамтран туурвисан 100 шахам ном бүтээлийн дотор манай орны аялал жуулчлалын ажил болон сургалт эрхлэгчдийн үндсэн гарын авлага болсон "Монгол орноор жуулчлах 100 зам", "Монгол орны газарзүйн нэрийн товч толь бичиг", манай улсын боловсролын түүхийн үндсэн тулгуур бүтээл болох "Монголын боловсролын түүх" (3 боть) зэрэг бүтээлүүд байгаа бөгөөд эдгээр нь англи хэл болон хуучин монгол бичгээр хэвлэгдэж гарсан байдаг. Түүнчлэн "Эх газрын газарзүй", "Монголын физик газарзүй", "ЕБС-д газарзүй заах арга" зэрэг сурах бичгүүдийг зохиож редакторласны дотроос "Монголын физик газарзүй" (зохиогч Ш.Цэгмид) сурах бичиг нь 1984 онд төрийн шагнал авсан юм.

Тэрбээр 1978 онд "Монголын нутгийн газар зүйн төв (хүйс) цэг Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Өвөр хөшөөтөд оршдог гэдгийг солбилцлын аргаар бодож тогтоосон нь онцгой ач холбогдолтой ажил болсон.

Төлийгаачийн хөдөлмөр бүтээлийг төр, засгаас үнэлж "Ардын гэгээрлийн тэргүүний ажилтан", "Байгаль орчны тэргүүний ажилтан", "Аялал жуулчлалын тэргүүний ажилтан", "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч" цол тэмдэг, "Засгийн газрын хүндэт жуух", "Алтан гадас" одон, "Монгол Улсын гавьяат багш", "Монгол Улсын Ардын багш" цолоор тус тус шагнажээ.

Түүний хүнлэг, эх оронч, хөдөлмөрч, элэгсэг дотно харьцаа гэгээн дүр нь бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн дурсагдах болно.

**Ц.ЭЛБЭГДОРЖ, М.ЭНХБОЛД, Ж.ЭРДЭНЭБАТ,
Л.ЭНХ-АМГАЛАН, Ж.БАТСУУРЬ, Ч.УЛААН, Ж.БАТЗАНДАН,
Б.ГАНСҮХ, З.ЭНХТӨР**